




ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт





ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2022 онд: 6%,
Инфляци: 2022 онд: 8.2%,
Урсгал тэнцэл: 2022 онд: -10.2%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2021 оны тайланд прогноз хийсэн байна.

Эх сурвалж: <https://bit.ly/30pG2Et>


ДНБ-ий өсөлт: 2022 онд: 7.5%
Инфляци: 2021 онд: 7.3%,
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2022 онд: -8.5%- Олон улсын валютын сан (ОУВС)-ийн тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <https://bit.ly/3ax1ORq>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 7-р сарын байдлаар 844 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 70.6 хувиар өссөн бол, зарлага 31.3 хувиар буурч төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 844 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 1.6 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.




Ам.долларын ханш өмнөх сараас 14.03 төгрөгөөр өсжээ.

Долоодугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 304 төгрөгөөр нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 28.78 төгрөгөөр өсөж 3153.03 төгрөг болов. 7-р сард гадаад валютын нөөц 2.8 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас -7.06 оны эхнээс 34.07 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 37.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.




Инфляцын түвшин 15.7%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2022 оны 7-р сарын байдлаар өмнөх сараас 1 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 15.7 хувиар, оны эхнээс 10.6 хувь өсөв. Ингэж өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 21.5 хувь (мах, махан бүтээгдэхүүн 3.0 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 29.4 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 9.4 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 13.8 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 11.3 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 17.9 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 18.7 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.




Гадаад худалдааны тэнцэл 1702 сая.ам долларын ашигтай гарав.

2022 оны долоодугаар сард нийт барааны эргэлт 11.227 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 30.8 хувиар өссөн бол экспорт өмнөх сараас 36.3 хувь, импорт өмнөх оны мөн үеэс 24 хувиар нэмэгдэж гадаад худалдааны тэнцэл 1702 сая ам.долларын ашигтай гарав.



7-Р САРЫН ОНЦЛОХ: ХАДГАЛАМЖ

Эх сурвалж: www.1212.mn

Нийт хадгаламж 2022 оны 7-р сард 17.8 их наяд төгрөг болж өмнөх сараас 495.7 тэрбум төгрөг буюу 2.7 хувиар буурсан бол өнгөрсөн оны мөн үеэс 7.7 хувиар буюу 311.6 тэрбум төгрөгөөр буурав. Тус сард төгрөгийн хадгаламж 13302 тэрбум төгрөг буюу өмнөх сараас 3.5 хувиар, валютын хадгаламж 4516 тэрбум төгрөг болж өмнөх сараас 0.2 хувиар тус тус буурав. Үүнээс төгрөгийн хадгаламж 75 хувь, валютын хадгаламж 25 хувийг эзэлж байна. Харин өнгөрсөн оны мөн үеэс төгрөгийн хадгаламж 12.5 хувиар буурсан бол валютын хадгаламж 10.2 хувиар нэмэгджээ.

САРЫН ОНЦЛОХ

МОНГОЛ УЛС ӨРСӨЛДӨХ ЧАДВАРААР 36.2 ОНООТОЙ БОЛЖ БУУРЧЭЭ

- Монгол Улсын өрсөлдөх чадвар олон улсын үзүүлэлтээр ахихгүй байна. Дэлхийн өрсөлдөх чадварын төвөөс жил бүр гаргадаг “Дэлхийн өрсөлдөх чадварын жилийн тайлан”-аас харж болно. Улс орныг хөгжүүлэх тогтвортой аюулгүй байдал, бизнесийн орчин хэрэгтэй талаар Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн Удирдах зөвлөлийн дарга Д.Цагаан онцлов. Судалгааны үр дүнгээс харахад Монгол Улс харьцуулах боломжтой, сонгогдсон 63 улсаас 61-рт эрэмбэлэгджээ. Энэ нь өмнөх оноос 1 эрэмбээр ухарсан үзүүлэлттэй байна. Нэгдүгээрт эрэмбэлэгддэг улсыг 100 оноотой гэж тооцон, бусад улсыг 100 оноотой харгалзах оноо өгч эрэмбэлдэг. Манай улсын хувьд өнгөрсөн жил 40.04 оноотой байсан бол энэ жил 36.2 болжээ.

ХӨГЖЛИЙН БАНК: ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТ 503,5 ТЭРБУМ ТӨГРӨГТ ХҮРЭВ

- Монгол Улсын Хөгжлийн банканд энэ оны 1 дүгээр сарын 20-ноос 7 дугаар сарын 18-ны өдрийн хооронд нийт 503,5 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөөд байна. Зээлийн төлөлтийг ангиллаар авч үзвэл:
 - хэвийн зээлдэгчийн ангилал дахь зээлийн эргэн төлөлт 94,8 тэрбум төгрөг,
 - анхаарал хандуулах ангиллын зээлийн эргэн төлөлт 126,8 тэрбум төгрөг,
 - чанаргүй зээлийн ангиллын зээлийн эргэн төлөлт 273,1 тэрбум төгрөг тус тус төлөгдөөд байна.

Эх сурвалж:

- Статистикийн бюллетень, 7-р сар 2022 он, Үндэсний статистикийн хороо
- Статистикийн бюллетень, 7-р сар 2022 он, Монголбанк
- www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn